

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/29/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батсайхан
Утас: 70453799

Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

2023.02.24 № УДА-2023/29/НА-СТА-ТЦЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

080900021

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over a handwritten signature in black ink. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

М.БАТСУУРЬ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,719,938,403.00	13,681,014,290.00
33	АВЛАГА	00.00	41,250,000.00
335	Бусад авлага	00.00	41,250,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	41,250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,719,938,403.00	13,639,764,290.00
354	Хангамжийн материал	12,719,938,403.00	13,639,764,290.00
35420	Аж ахуйн материал	17,677,164.00	17,677,164.00
35470	Бусад хангамжийн материал	12,702,261,239.00	13,622,087,126.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,688,197,104.70	3,754,025,386.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,688,197,104.70	3,754,025,386.31
392	Биет хөрөнгө	2,422,017,104.70	3,162,533,886.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,147,165,668.26	2,710,456,339.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	-524,186,138.38	-649,731,457.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	662,130,749.00	632,130,749.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-501,653,249.21	-533,264,082.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	916,497,652.31	1,183,620,277.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-342,971,239.75	-376,524,662.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	342,847,910.50	484,263,338.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-277,814,248.03	-288,416,615.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,000,000.00	-6,000,000.00
393	Биет бус хөрөнгө	266,180,000.00	591,491,499.96
39301	Програм хангамж	47,975,000.00	47,975,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-47,975,000.00	-47,975,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	266,180,000.00	603,804,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-12,312,500.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,408,135,507.70	17,435,039,676.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	41,250,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	41,250,000.00
413	Өглөг	00.00	41,250,000.00
4136	Бусад өглөг	00.00	41,250,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	41,250,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,408,135,507.70	17,393,789,676.31
51	Засгийн газрын хувь оролцоо	15,408,135,507.70	17,393,789,676.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,137,238,557.94	1,137,238,557.94
51101	Өмч: - төрийн	1,137,238,557.94	1,137,238,557.94
512	Хуримтлагдсан үр дүн	13,566,636,143.92	15,572,620,295.53
51210	Өмнөх үеийн үр дүн	13,566,636,143.92	13,586,966,126.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,985,654,168.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	704,260,805.84	683,930,822.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,408,135,507.70	17,435,039,676.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,766,569,990.37	5,754,701,120.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,545,036.37	2,475,645,834.00
120	Нийтлэг татварын бус орлого	86,545,036.37	2,475,645,834.00
120001	Хувьцааны ногдол ашиг	62,871,515.37	1,489,212,677.00
120002	Хүүгийн орлого	00.00	975,881,657.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,673,521.00	10,551,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,673,521.00	10,551,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,680,024,954.00	3,279,055,286.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	287,024,854.00	1,008,666,486.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,423,306.00	234,971,472.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,601,548.00	646,554,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	126,140,914.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,393,000,100.00	2,270,388,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,393,000,100.00	2,270,388,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,800,219,232.40	3,677,943,796.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,800,219,232.40	3,677,943,796.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,574,873,341.11	3,487,299,467.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,123,768,766.82	1,065,029,301.27
210101	Үндсэн цалин	769,139,620.02	735,887,119.97
210102	Нэмэгдэл	00.00	184,992,758.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,764,359.28
210104	Урамшуулал	00.00	75,269,379.60
210105	Гэрээт ажлын хөлс	354,629,146.80	27,115,684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,575,045.31	125,636,783.45
210201	Тэтгэврийн даатгал	95,612,354.57	85,730,011.59
210202	Тэтгэмжийн даатгал	10,498,764.43	10,013,643.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,358,451.91	7,846,275.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,838.82	1,903,296.04
210205	Эрүүл мэндийн даатгал	21,058,635.58	20,143,556.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,753,930.00	137,651,303.42
210301	Гэрэл, цахилгаан	11,984,637.00	10,199,402.12
210302	Түлш, халаалт	142,193,679.00	118,974,996.30
210303	Цэвэр, бохир ус	12,575,614.00	8,476,905.00

2104	Хангамж, бараа материалын зардал	4,959,543,242.58	223,803,476.00
210401	Бичиг хэрэг	15,734,700.00	14,973,100.00
210402	Тээвэр, шатахуун	89,509,500.00	119,291,352.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,818,373.58	19,614,635.00
210404	Ном, хэвлэл	1,699,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,300.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,500,890.00	13,868,619.00
210408	Бараа материал акалсны зардал	4,808,446,979.00	56,055,770.00
2105	Нормативт зардал	1,980,000.00	1,960,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,977,800.00	45,846,900.00
210604	Урсгал засвар	67,977,800.00	45,846,900.00
2107	Томилолт, зочны зардал	38,452,900.00	108,497,043.00
210702	Дотоод албан томилолт	38,452,900.00	108,497,043.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,000,684.00	24,983,441.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,200,000.00	7,056,766.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	876,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,599,560.00	5,603,725.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	814,764.00	1,127,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.00	7,470,800.00
210807	Газрын төлбөр	1,746,360.00	2,551,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,047,820,972.40	1,753,891,219.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	662,394,033.00	1,331,536,079.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,302,252.00	65,265,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	316,124,687.40	357,089,240.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,345,891.29	190,644,328.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,918,922.00	103,445,868.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,325,300.00	16,881,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,593,622.00	86,564,468.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	77,426,969.29	87,198,460.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,426,969.29	87,198,460.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,033,649,242.03	2,076,757,323.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,338,456.83	91,103,154.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,338,456.83	91,103,154.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-15,338,456.83	-91,103,154.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,048,987,698.86	1,985,654,168.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,774,149,975.00	3,289,606,786.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,673,521.00	10,551,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,673,521.00	10,551,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,673,521.00	10,551,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,673,521.00	10,551,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,750,476,454.00	3,279,055,286.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,476,354.00	1,008,666,486.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,423,306.00	234,971,472.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	181,601,548.00	646,554,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,451,500.00	126,140,914.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,393,000,100.00	2,270,388,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,393,000,100.00	2,270,388,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,734,349,975.00	3,289,606,786.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,734,349,975.00	3,289,606,786.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,509,004,083.71	3,098,962,457.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,124,009,185.82	1,065,029,301.27
210101	Үндсэн цалин	769,380,039.02	735,887,119.97
210102	Нэмэгдэл	00.00	184,992,758.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,764,359.28
210104	Урамшуулал	00.00	75,269,379.60
210105	Гэрээт ажлын хөлс	354,629,146.80	27,115,684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,291,635.31	125,636,783.45
210201	Тэтгэврийн даатгал	95,328,944.57	85,730,011.59
210202	Тэтгэмжийн даатгал	10,498,764.43	10,013,643.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,358,451.91	7,846,275.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,838.82	1,903,296.04
210205	Эрүүл мэндийн даатгал	21,058,635.58	20,143,556.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,753,930.00	137,651,303.42
210301	Гэрэл, цахилгаан	11,984,637.00	10,199,402.12
210302	Түлш, халаалт	142,193,679.00	118,974,996.30
210303	Цэвэр, бохир ус	12,575,614.00	8,476,905.00
2104	Хангамж, бараа материалын зардал	151,400,273.58	167,747,706.00
210401	Бичиг хэрэг	15,828,700.00	14,973,100.00
210402	Тээвэр, шатахуун	89,509,500.00	119,291,352.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,818,373.58	19,614,635.00

210404	Ном, хэвлэл	1,699,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,300.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,710,900.00	13,868,619.00
2105	Нормативт зардал	1,980,000.00	1,960,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,039,200.00	70,654,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,171,300.00	23,193,000.00
210602	Тавилга	4,951,100.00	1,615,000.00
210604	Урсгал засвар	69,916,800.00	45,846,900.00
2107	Томилолт, зочны зардал	38,452,900.00	108,497,043.00
210702	Дотоод албан томилолт	38,452,900.00	108,497,043.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,000,684.00	24,983,441.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,200,000.00	7,056,766.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	876,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,599,560.00	5,603,725.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	814,764.00	1,127,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.00	7,470,800.00
210807	Газрын төлбөр	1,746,360.00	2,551,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	736,076,275.00	1,396,801,979.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	666,774,023.00	1,331,536,079.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,302,252.00	65,265,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,345,891.29	190,644,328.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,918,922.00	103,445,868.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79,325,300.00	16,881,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,593,622.00	86,564,468.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	77,426,969.29	87,198,460.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,426,969.29	87,198,460.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>39,800,000.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>39,800,000.00</u>	<u>00.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>39,800,000.00</u>	<u>00.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	39,800,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	39,800,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-39,800,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	972,308,557.94	943,975,009.00	213,487,997.47	2,129,771,564.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	972,308,557.94	943,975,009.00	213,487,997.47	2,129,771,564.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,906,491.01	-57,906,491.01
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,137,238,557.94	704,260,805.84	13,566,636,143.92	15,408,135,507.70
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,137,238,557.94	704,260,805.84	13,566,636,143.92	15,408,135,507.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	20,329,983.00	20,329,983.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,137,238,557.94	704,260,805.84	13,586,966,126.92	15,428,465,490.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-20,329,983.00	00.00	-20,329,983.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,985,654,168.61	1,985,654,168.61
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,137,238,557.94	683,930,822.84	15,572,620,295.53	17,393,789,676.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,280,388,800.00	2,235,640,042.14	44,748,757.86	98.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,280,388,800.00	2,235,640,042.14	44,748,757.86	98.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,218,287,700.00	2,173,540,096.14	44,747,603.86	97.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,065,424,200.00	1,037,913,617.27	27,510,582.73	97.42
210101	Үндсэн цалин	753,770,700.00	735,887,119.97	17,883,580.03	97.63
210102	Нэмэгдэл	181,578,300.00	184,992,758.42	-3,414,458.42	101.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,000,000.00	41,764,359.28	3,235,640.72	92.81
210104	Урамшуулал	85,075,200.00	75,269,379.60	9,805,820.40	88.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,081,900.00	125,636,783.45	13,445,116.55	90.33
210201	Тэтгэврийн даатгал	94,575,600.00	85,730,011.59	8,845,588.41	90.65
210202	Тэтгэмжийн даатгал	11,126,500.00	10,013,643.80	1,112,856.20	90.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,901,300.00	7,846,275.04	1,055,024.96	88.15
210204	Ажилгүйдлийн даатгал	2,225,300.00	1,903,296.04	322,003.96	85.53
210205	Эрүүл мэндийн даатгал	22,253,200.00	20,143,556.98	2,109,643.02	90.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,458,000.00	137,651,303.42	806,696.58	99.42
210301	Гэрэл, цахилгаан	10,485,600.00	10,199,402.12	286,197.88	97.27
210302	Түлш, халаалт	119,124,400.00	118,974,996.30	149,403.70	99.87
210303	Цэвэр, бохир ус	8,848,000.00	8,476,905.00	371,095.00	95.81
2104	Хангамж, бараа материалын зардал	157,516,100.00	156,667,179.00	848,921.00	99.46
210401	Бичиг хэрэг	14,981,200.00	14,973,100.00	8,100.00	99.95
210402	Тээвэр, шатахуун	109,312,600.00	109,310,825.00	1,775.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,618,000.00	19,614,635.00	3,365.00	99.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,300.00	0.00	833,300.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,771,000.00	12,768,619.00	2,381.00	99.98
2105	Нормативт зардал	1,980,000.00	1,960,000.00	20,000.00	98.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,960,000.00	20,000.00	98.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,800,000.00	57,654,900.00	145,100.00	99.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,271,300.00	10,193,000.00	78,300.00	99.24
210602	Тавилга	1,666,700.00	1,615,000.00	51,700.00	96.90
210604	Урсгал засвар	45,862,000.00	45,846,900.00	15,100.00	99.97
2107	Томилолт, зочны зардал	85,204,600.00	85,160,793.00	43,807.00	99.95
210702	Дотоод албан томилолт	85,204,600.00	85,160,793.00	43,807.00	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,823,400.00	23,983,441.00	839,959.00	96.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,167,200.00	7,056,766.00	110,434.00	98.46

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	876,000.00	876,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,672,400.00	5,603,725.00	68,675.00	98.79
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,410,700.00	1,127,550.00	283,150.00	79.93
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	445,500.00	297,000.00	148,500.00	66.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.00	7,470,800.00	29,200.00	99.61
210807	Газрын төлбөр	1,751,600.00	1,551,600.00	200,000.00	88.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	547,999,500.00	546,912,079.00	1,087,421.00	99.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	517,385,100.00	516,611,079.00	774,021.00	99.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,614,400.00	30,301,000.00	313,400.00	98.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,101,100.00	62,099,946.00	1,154.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,101,100.00	62,099,946.00	1,154.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,881,400.00	16,881,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,219,700.00	45,218,546.00	1,154.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,280,388,800.00	2,235,640,042.14	44,748,757.86	98.04
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,270,388,800.00	2,225,088,542.14	45,300,257.86	98.00
320001	Орон нутгийн төсвөөс	2,270,388,800.00	2,225,088,542.14	45,300,257.86	98.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	10,551,500.00	-551,500.00	105.52
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,551,500.00	-551,500.00	105.52

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
			1008666486	-1008666486	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1008666486	-1008666486	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		925422361	-925422361	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27115684	-27115684	
210105	Гэрээт ажлын хөлс		27115684	-27115684	
2104	Хангамж, бараа материалын зардал		11080527	-11080527	
210402	Тээвэр, шатахуун		9980527	-9980527	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1100000	-1100000	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		13000000	-13000000	
210601	Багаж, техник, хэрэгсэл		13000000	-13000000	
2107	Томилолт, зочны зардал		23336250	-23336250	
210702	Дотоод албан томилолт		23336250	-23336250	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1000000	-1000000	
210807	Газрын төлбөр		1000000	-1000000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		849889900	-849889900	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		814925000	-814925000	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		34964900	-34964900	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		83244125	-83244125	
2132	Бусад урсгал шилжүүлэг		41345922	-41345922	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		41345922	-41345922	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		41898203	-41898203	
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		41898203	-41898203	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1008666486	-1008666486	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1008666486	-1008666486	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1000000	-1000000	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		234971472	-234971472	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		646554100	-646554100	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		126140914	-126140914	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,377.8 мянган төгрөгөөр буюу 41.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	41,250.0	41,250.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	12,719,938.4	13,639,964.3	920,025.9
Үндсэн хөрөнгө	2,688,197.1	3,754,025.4	1,065,828.3
Нийт хөрөнгө	15,408,135.5	17,435,039.7	2,026,904.2
Өр төлбөр	0.0	41,250.0	41,250.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,137,238.5	1,137,238.5	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,408,135.5	17,435,039.7	2,026,904.2

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 41,250.0 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 975,881.6 мянган төгрөгийн дуусаагүй ажлуудыг бусад хангамжийн материалын хэсэгт бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 574,675.4 мянган төгрөгөөр барилга, байгууламж, 406,675.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 156,396.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 367,400.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 41,250.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,813,524.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд тайлант онд 2,280,388.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,270,388.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөг, нийт 2,280,388.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,280,388.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,235,640.0 мянган төгрөг буюу 98.04 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн удирдлага	2,280,388.8	2,235,640.0	44,748.7	98.04%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 234,971.5 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 646,554.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 126,140.9 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 1,000.0 мянга, нийт 1,008,666.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт ажлын хөлс 27,115.7 мянга, тээвэр шатахууны зардалд 9,980.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 1,100.0 мянга, багаж техник, хэрэгсэл 13,000.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 23,336.2 мянга, газрын төлбөр 1,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 814,925.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 34,964.9 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 41,345.9 мянга төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Засаг даргын тамгын газрын дарга Г.Болор-эрдэнэд танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/247 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Засаг даргын тамгын газрын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2021 оны нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,677,943.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 18,389.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,711.8 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засаг даргын зөвлөхөөр ажиллаж байсан 2 албан тушаалтныг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/55, Б56 дугаартай захирамжаар чөлөөлсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/83 дугаар “Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал, Монгол улсын Ерөнхий аудиторын орлогчийн 7 дугаар сарын 07-ны өдрийн 01/167 дугаар албан бичгийн дагуу “Увс аймгийн Засаг даргын захирамж болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг үндэслэн 2021, 2022 онд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт нийцлийн хийсэн.

Уг аудитаар 15,448.0 мянган төгрөгийн зарцуулалт нь Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл байхгүй, зарцуулсан хүчин төгөлдөр анхан шатны санхүүгийн баримтаар нотлогдохгүй байгаа зөрчил илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

Түүнчлэн тайлант онд Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 2 хүнд ажилгүй байсан хугацааны нийт 20,790.9 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна. Уг асуудлыг Захиргааны ерөнхий тухай хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт аудитын албан болон Төрийн албаны Увс аймаг дахь салбар зөвлөлд хандаж шийдвэрлүүлэхээр болов.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа хоцроож 9 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 123 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Н.Цогт-Очирыг томилсон Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Б/29 дүгээр тушаал, Зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 124 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Эрдэнэтогтохыг томилсон Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/65 дугаар тушаалыг хүчингүй болгосон байхад тухайн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэсээр байна. Уг асуудлыг Төрийн албаны зөвлөлд хандаж шийдвэрлүүлэхээр болов.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 02 сарын 24-ны өдөр